

## ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

### БИДНИЙ ҮҮРЭГ АМЛАЛТ:

- Хог хаягдлыг бууруулах үр дүнтэй арга техникийг ашиглах замаар хог хаягдлын хэмжээг бууруулах
- Олон улсын тэргүүлэх туршлага болон шинэлэг шийдлийг ашиглан хог хаягдлыг хариуцлагатайгаар зохицуулах
- Хог хаягдлыг боловсруулах, устгах чиглэлээр олон улсын стандартад нийцэхийн тулд дахин ашиглах, боловсруулан ашиглах үйл явцыг хэрэгжүүлэх
- Бүс нутгийн хог хаягдлын менежментийн байгууламжийг байгуулахад дэмжлэг үзүүлэх.

### ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ:

Хог хаягдал нь үндсэндээ доорх зүйлсээс үүснэ:

- Хаягдал чулуулаг болон баяжуулах үйлдвэрлэлийн хаягдал гэх зэрэг хүдрийн хог хаягдал буюу (жишээ нь бутлагдсан чулуулаг, бага агуулгатай хүдрийн хаягдал гэх мэт)
- Барилгын хог (хаягдал төмөр, бетон), ахуйн хог хаягдал (хүнсний зүйлс, цаас гэх мэт) болон эмнэлгийн хог хаягдал зэргийг багтаасан хүдрийн бус хог хаягдал
- Кемпийн байгууламжуудаас гарах ахуйн бохир ус.

### БИДНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:

ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ САНААЧИЛГУУД:

- Уурхайн төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, сав, баглаа боодлыг (жишээ нь хуванцар сав) устгах замаар хог хаягдлыг багасгах





- Хаягдлыг бууруулах, боловсруулан дахин ашиглах зэрэгт чиглэгдсэн ажилчдад мэдлэг олгох кампанит ажлыг хэрэгжүүлэх
- Хог хаягдлыг шинэлэг байдлаар дахин ашиглах (жишээ нь технологийн усыг 100 хүртэл хувь эргүүлэн ашиглах)
- Тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Монголын компаниудыг ашиглан хог хаягдлыг боловсруулан дахин ашиглах (жишээ нь метал, картон, мод, хуванцар, тос гэх мэт).

#### ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ:

- Оюу Толгойн уурхайн талбайд хог хаягдал боловсруулах, зайлуулах үйл явцыг зөв зохистой удирдах
- Олон улсын стандартын хог хаягдлын менежментийн төв (дарж булах ландфилл болон шатаах байгууламж) болон ахуйн бохир усыг цэвэрлэх байгууламж байгуулах
- Хаягдал хадгалах байгууламж болон хаягдал чулуулгийн овоолгын зохистой менежментийг баталгаажуулах.

#### БҮС НУТГИЙН ХОГ ХАЯГДЛЫН САЙЖРУУЛСАН МЕНЕЖМЕНТИЙГ ДЭМЖИХ:

- Ханбогд сумын засаг захиргаатай хамтран Ханбогд суманд хог хаягдлын ландфиллийн байгууламж байгуулах.

Дэлгэрэнгүй мэдээллийг Байгаль орчин, нийгмийн нөлөөлийн үнэлгээнд (БОННУ) тусгагдсан Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө болон Шилжилт хөдөлгөөний менежментийн төлөвлөгөөнөөс үзнэ үү.

БОННУ-г [www.ot.mn](http://www.ot.mn) цахим хуудас болон дор дурьдсан олон нийтийн газруудаас авч болно:

- Ханбогд, Манлай, Баян-Овоо болон Даланзадгад сумд дахь Оюу Толгойн салбар оффис
- **Ханбогд сум:** Ёслолын Өргөө
- **Манлай сум:** ЗДТГ-ын Мэдээллийн танхим
- **Баян-Овоо сум:** Дунд сургууль
- **Даланзадгад:** Төв номын сан болон Иргэний танхим
- **Улаанбаатар:** Оюу Толгойн Мэдээллийн Төв.